



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/196

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалт, Засгийн газрын 2010 оны “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 271 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан Говьсүмбэр аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтын 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн баяр наадмыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн үндэсний их баяр наадмын бай шагнал болон бусад зардалд шаардагдах 30,000,000 (гучин сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сан, 20,833,300 (хорин сая найман зуун гучин гурван мянга гурван зуун) төгрөгийг Засаг даргын тамгын газрын төсвөөс, 31,406,700 (гучин нэгэн сая дөрвөн зуун зургаан мянга долоон зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс, 16,260,000 (арван зургаан сая хоёр зуун жаран мянган) төгрөгийг баяр наадмын үйл ажиллагааны орлогоос тус тус зарцуулахыг зөвшөөрсүгэй.

3. Дээрх наадмын зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Содном)-д үүрэг болгосугай.

4. Баяр наадмын зардлыг хавсралтын дагуу үр ашигтай зарцуулж, гүйцэтгэлийг эргэн тайлагнахыг баяр наадмыг зохион байгуулах салбар хорооны дарга (Б.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ



Аймгийн Засаг даргын 2022 оны 06.
дугаар сарын 27-ны өдрийн 17/196
дугаар захирамжийн хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯР НААДМЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зохион байгуулах салбар хороо	Зардал
1	Хурдан морины салбар	28,678,000
2	Үндэсний бөхийн салбар	5,862,640
3	Сур, шагайн харвааны салбар	8,449,500
4	Соёл, урлагын салбар	10,672,000
5	Худалдаа, үйлчилгээ, тохижилтийн салбар	2,128,000
6	Хэв журам сахиулах салбар	5,585,730
7	Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах аж ахуй	37,124,130
Нийт дүн		98,500,000